



МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГАА

МОНГОЛ-СОЛОНГОСЫН ДАЛАЙ АШИГЛАЛТ, УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ТӨЛӨВ



ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ТАНИЛЦУУЛГА

- Хөлөг онгоцны бүртгэл, хяналт
- Усан замын тээврийн бүртгэл, хяналт
- Хуурай боомт, далайн тээвэр



Хөлөг онгоцны бүртгэл, хяналт



Монгол Улсын Далайн захиргаа хөлөг онгоцны нээлттэй бүртгэлийн үйл ажиллагаа явуулж байна.



БНСУ-ын хөлөг онгоцны бүртгэлийн зуучлагч агент “Cosmos Marine Bureau” компаниар дамжин манай улсын бүртгэлд 59,439 тонн даац бүхий 40 хөлөг онгоц Монгол Улсын төрийн далбааг мандуулан их далайд аялж байна. Үүнээс:

- Ерөнхий ачаа тээврийн онгоц – 21
- Чиргүүл хөлөг онгоц – 10
- Хөлдөөсөн бүтээгдэхүүн тээвэрлэгч хөлөг онгоц – 4
- Загас агнуурын хөлөг онгоц – 2
- Элс тээвэрлэгч хөлөг онгоц – 1
- Буксир буюу чирэгч, түлхэгч хөлөг онгоц – 1
- Тээврийн хэрэгсэл, техник тээвэрлэгч – 1



БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын технологийн институт (KIMFT)-д МУДЗ нийт 13 боловсон хүчнээ сургалтанд хамруулаад байна. БНСУ-д бэлтгэгдсэн 3 албан хаагч одоогоор МУДЗ-нд ажиллаж байна. БНСУ-ын Далайн захиргаа нь манай албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх тал дээр сүүлийн 10 жилийн хугацаанд дэмжлэг үзүүлж ажилласаар байна.





Усан замын тээврийн бүртгэл хяналт

Дотоодын усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг жил бүр хийж, тоо бүртгэл, гэрчилгээ, улсын дугаар олгох, хуулийн хэрэгжилтийг хангуулж үйл ажиллагаа явуулж байна.

4 бага оврын усан онгоц, 202 моторт завь бүртгэлтэй байгаагаас 1 моторт завь БНСУ-д үйлдвэрлэсэн байна.

БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын технологийн институттэй 2013 оноос хамтын ажиллагаа эхлүүлсэн. БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын технологийн институт, Далайн аюулгүй байдлын захиргаа болон Монгол Улсын Далайн захиргаа хооронд 3 талт хамтын ажиллагааны Санамж бичгийг байгуулсны дагуу 2022 оны 8 дугаар сард тус институтын холбогдох төлөөлөгчид Монгол Улсад амжилттай ажиллаад буцав.

БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын яамны санхүүжилтээр БНСУ-ын Далайн шинжлэх ухаан, технологийн хүрээлэн (KIOST)-тэй хамтран

- “Хөвсгөл нуур дээр усан замын тээврийн судалгаа, эко усан зогсоол байгуулах ТЭЗҮ боловсруулах” төсөл
- “Хөвсгөл нуур дээр судалгааны усан онгоц нэвтрүүлэх төсөл” боловсруулан БНСУ-ын талд хүргүүлсэн.





Боомт ашиглалт, далайн тээвэр



Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу Монгол Улсын уул уурхайн экспортын бүтээгдэхүүнийг ОХУ, БНХАУ-ын далайн боомтуудаас БНСУ, Япон зэрэг орон руу тээвэрлэх зорилго бүхий Монгол, Солонгосын хамтарсан “Монгол-Саммок Ложистик” ХХК-ийг 2015 онд БНСУ-д байгуулсан.

БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын технологийн хүрээлэнтэй байгуулсан хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичгийн хүрээнд БНСУ-ын “Саммок Шиппинг” ХХК-ийн дэмжлэгтэйгээр 2013 оноос хойш удирдах түвшний нийт 10 далайчин, 3 туслах далайчинг тус тус бэлтгэсэн байна.

Далайн захиргааны холбогдох албан хаагчид БНСУ-ын Бусан хотноо усан онгоц дээрх аюулгүй ажиллагаа болон техникийн хяналтын үзлэг, шалгалт хийх 2 удаагийн сургалтад хамрагдав.






Цаашид хамтран ажиллах боломж

- Хөлөг онгоц бүртгэл, хяналтын ажлын хүрээнд цаашид далбааны эзэн улсын хяналтын байцаагчдыг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах
- Усан замын тээврийн бүртгэл, хяналтын ажлын хүрээнд БНСУ-ын холбогдох байгууллагуудад өргөн барьсан төслийг эрчимжүүлж хамтран ажиллах
- Хуурай боомт, далайн тээврийн ажлын хүрээнд Монгол Улсын 8 байршилд Хуурай боомт байгуулахаар шийдвэрлэгдээд байгаа ба Замын-Үүд, Сайншанд, Улаанбаатар, Хөшигийн Хөндий, Алтан-Булаг, Ховд, Чойбалсан, Бичигт боомд дээр хамтран ажиллах боломж бололцоо нээлттэй байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа



**MONGOLIA MARITIME
ADMINISTRATION**

Tel: +976 7011-4802
Email: info@monmarad.gov.mn
Website: www.monmarad.gov.mn